

БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л МӨНХЗУЛ

2026 оны сарын өдөр

Урианбаатар хот

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ХАРИЛЦАХ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА БЭЛТГЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР

АЖЛЫН ЗОРИЛГО: Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах тэдний онцлогт тохируулж үйлчилгээ үзүүлэх талаар мэдвэл зохих агуулгуудыг багтаасан гарын авлага боловсруулж, олон нийтэд хүргэн иргэд, байгууллагын харилцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр
Дуусах хугацаа: 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад 107.2 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.1 хувийг эзэлж байна. Эдгээр иргэдийн 12 мянга нь харааны, 7.8 мянга нь сонсголын, 20 мянга нь хөдөлгөөний, 21.3 мянга нь сэтгэцийн, 3.6 мянга нь хэл ярианы, 7.4 мянга нь хавсарсан, 39 мянга нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохируулж харилцах, үйлчилгээ үзүүлэх талаар олон нийт, үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд болон хүмүүст зориулсан арга зүйн дэмжлэг үзүүлэх товч, тодорхой мэдээлэл бүхий гарын авлага боловсруулан нийтэд хүргэх зайлшгүй шаардлагатай байна.

ХОЁР. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах тэдний онцлогт тохируулж үйлчилгээ үзүүлэх талаар мэдвэл зохих агуулгуудыг багтаасан гарын авлага боловсруулж, ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Багцад тусгагдсан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Агуулга	Тоо ширхэг	Шаардлага	Төсөв (мян төг)	Хугацаа
1	Дэлгэрэнгүй гарын авлага	-Харааны бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт, мэдээллийг товч, ойлгомжтой	А4 хэмжээ 10 хуудаснаас	- Олон нийтэд ойлгомжтой, батлагдсан нэршил үг	3,800	IV/08-IV/25

		байдлаар багтаасан байх; - Тухайн бэрхшээлээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үүсч болох онцлог хэрэгцээ, үйлчилгээ авахад шаардлагатай хэрэглэгдэхүүнүүдийг тодорхой тусгасан байх; -Тухайн бэрхшээлтэй хүнтэй харилцах харилцааны онцлог арга хэлбэр, шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тодорхой тусгасан байх; -Тухайн бэрхшээлтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд үүсч болох хүндрэл бэрхшээл, тусламж дэмжлэгийн талаар тодорхой тусгасан байх; -Харааны бэрхшээлтэй хүний давуу тал, ур чадварыг бэрхшээлийн төрөлтэй уялдуулан тодорхойлж тусгасан байх;	багагүй байх A4 хэмжээний 3 хуудаснаас багагүй байх	хэллэгийг ашигласан байх; - Хүний анхаарал татахуйц өнгө загвартай, орчин үеийн шийдэлд суурилсан байх;	1,200	IV/25-V/10
3.	Эцсийн тайлан ирүүлэх	Бэлтгэсэн мэдээллийн цаасаар болон файлаар хавсаргах		Тайлан 2 ширхэг бүтээгдэхүүн		VI/08

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь баг, иргэн байж болох ба дараах шаардлагыг хангасан байна.

Туршлага:
<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээл, түүний төрөл хэлбэр, онцлогийн талаар ойлголттой, тус салбарт ажиллаж байсан туршлагатай байх; • Ижил төрлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх; • Хууль, эрх зүй, хүний эрхэд суурилсан мэдээлэл боловсруулах чадвартай байх.

ТАВ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Тус яамны Гэр бүлийн бодлогын газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗУРГАА.САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлнэ. Арга хэмжээний төлбөр нь 5,000,000 /таван сая/ төгрөг байна.

Бүтээгдэхүүн хүлээн авч, хянаж төлбөрийг 100 хувь төлнө.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд төлбөрт бүх зардал, татвар, хураамж багтсан болно.

ДОЛОО.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Ажил гүйцэтгэгчийн болон багийн гишүүдийн анкет
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг

---oOo---